

Цусны донорын талаарх хүн амын хандлага, Монгол улс, 2019 он

Оюунцэцэг Д.¹, Сувд Б.², Энхжаргал А.³, Эрдэнэбаяр Н.⁴

¹"Ач" АУИС-ийн докторант, ²Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв,

³Анагаахын мэргэжилтнүүдийн академи,

⁴Цус сэлбэлт судлалын үндэсний төв

e-mail: oyun.dash@yahoo.com

Abstract

Attitude towards to blood donation among population, Mongolia, 2019

Oyuntsetseg D.¹, Suvd B.², Enkhjargal A.³, Erdenebayar N.⁴

¹"Ach" Medical University, ²National Center for Public Health

³Academy of Medical Professionals, ⁴National Blood Center

e-mail: oyun.dash@yahoo.com

Background

Blood is an important resource, both for planned treatments and urgent interventions. It can help patients suffering from life-threatening conditions live longer and with a higher quality of life, and supports complex medical and surgical procedures. According to WHO recommendation at least 1% of the population of any country needs to donate their blood to accommodate the basic clinical needs of the country. Accordingly, we aimed to assess existing attitudes of the general population towards on blood donors.

Materials and Methods

The survey identified attitude of the population on blood donation and factors influencing them, using quantitative and qualitative methods. The survey covered a population aged 18-60 years. SPSS software version 21 was used for data analysis of the survey. The survey protocol and methodology were reviewed and approved by the Scientific Committee at the NCPH. The Medical Ethical Committee at the MOH reviewed the survey materials and issued an approval (2015/3).

Results

The survey covered in total 3,782 people and there are 59.2% of surveyed respondents said they have never thought of becoming a voluntary blood donor. Positive attitude on blood donation is higher with statistical significance among women (59.0%), 18-25 years old (43.7%) and UB residents citizens with higher education. As education level increases the number of respondents who thought about donating blood is also increases. 16.1% of them had a history of blood donation before and 38.2% said they never thought about it. Twenty point four percent of respondents thought blood donation brings some kind of risk. Nevertheless of the education level of surveyed respondents, the percentage of answer blood donation is not risky for a person was the most common answer. But respondent who is only literal and uneducated were don't know about whether it has a risk or not ($385.37=2\kappa$, $p=0.000001$). Also, respondents failed to donate their blood because the family not allowed, afraid, risk of infection, doesn't want and had a busy schedule.

Conclusion

There is a high tendency to donate blood populations of young people aged 20-29, women, residents of Ulaanbaatar, and uneducated and highly educated. The majority of respondents agreed that blood donating is charity and a good deed. The leading causes of blood donation is the education, gender, the desire of doing a good deed, peer influence and health condition.

Key words: Attitude, Blood Donation, Blood Transfusion Services, Donors, Health Personnel

Pp. 38-47, Tables 7, Figures 4, References 15

Үндэслэл

Донорын бэлэглэсэн цус олон сая хүний амийг авардаг юм. Дэлхийд, эмнэлзүйн анагаах ухааны хөгжил, хүн амын өсөлтөөс хамаарч цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээ байнга өсөн нэмэгдэж байна. Цус сэлбэх албаны үр дүнтэй үйл ажиллагааны үндэс нь аюулгүй, хүртээмжтэй цус цуглуулах юм. Аюулгүй, хүртээмжтэй цус цуглуулах үйл ажиллагаа нь цусны доноруудын байнгын тогтмол цусаа бэлэглэх явдлыг дэмжих замаар хэрэгжинэ. Сайн дураар цусаа бэлэглэх донорыг элсүүлэх шилдэг арга нь эрсдэл багатай хүн амыг татан оролцуулах явдал билээ. ДЭМБ-аас халдварын аливаа эрсдэлгүй цусаар хангах үндсэн боломжийн нэг нь 100% донороос цус цуглуулах явдал гэж үздэг. ДЭМБ-ын зөвлөмжид аливаа улс орны хүн амын 1 хувиас доошгүй нь цус хандивлаж байж улс орны цусны хэрэглээний наад захын хэрэгцээ шаардлагыг хангах боломжтой хэмээн тооцоолсон байдаг [1-3]. 2007 онд Монгол улсын УИХ-ын 45 дугаар тогтоолоор “Донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлогын баримт бичгийг баталсан” явдал нь аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний хангамжийн асуудал нь төр, засгийн газрын анхаарлын төвд байгааг илэрхийлнэ [4]. Энэ бодлогоор эмчилгээний үр дүн сайтай, аюулгүй, чанарын баталгаатай цус, цусан бүтээгдэхүүнээр эрүүл мэндийн байгууллагыг тасралтгүй хангах, гамшгийн үеийн хүрэлцээтэй нөөцийг улсын хэмжээнд бүрдүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон.

Манай улс 1994 оноос хойш цусны донорын тогтолцоонд шилжиж 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр донорын тухай хуулийг шинэчлэн баталгаажуулсан. Ингэснээр цусны донорын зохион байгуулалт, цусны аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин боловсронгуй болсон байна [5-6]. Цусны мэргэжлийн байгууллага болох Цус, сэлбэлт судлалын үндэсний төв, 21 аймгийн төвийн 26 цусны төвүүд ажиллаж сайн дураар цус хандивлагчдын тоог нэмэгдүүлэхийг чармайж байгаа боловч ДЭМБ-ын зөвлөмж болгож буй нийт хүн амын 1 хувь нь цусаа сайн дураараа бэлэглэхгүй байна. Иймд хүн амын цусны донор болоход нөлөөлж буй нийгэм, соёлын хүчин зүйлсийг тогтоож донорын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зорилго. Цусны донорын талаарх хүн амын хандлагыг судалж, цусаа өгдөггүй шалтгааныг тодорхойлох

Материал, арга зүй

Аналитик судалгааны агшингийн загвараар тоон болон чанарын аргаар гүйцэтгэлээ. Судалгаанд бүсийн төлөөлөл болсон 4 аймаг, УБ хотын 6 дүүргийн 18-60 насны санамсаргүйгээр сонгогдсон хүн амыг хамруулав. Нийт хүн амын 3.9 хувийг эзэлж буй Баян-Өлгий аймгийн казах үндэстний төлөөллийг зорилтот түүвэрлэлтийн аргаар сонгон оролцуулсан. Түүврийн хэмжээг тогтооходоо суурь судалгаагаар хүн амын 46.3 хувь нь цусны донорын талаар мэдлэггүй гэсэн үзүүлэлтийг харгалзан үзэж, 95 хувийн үнэн магадлал ($z=1.96$), алдааны хязгаар ($p=0.05$), комплекс түүврийн нөлөөллийн коэффициент (1.5), насны бүлэг бүрт хүйсийн төлөөлөл тэнцвэртэй байх (хүйс бүрт 3 насны бүлэг) зарчмуудыг баримталж нийт 3438 орчим хүнийг хамруулах тооцоо гарснаас сонгогдсон хүмүүс судалгаанд оролцохоос татгалзах магадлалыг 10 хувиар тооцоолон нэмж нийт 3782 хүнийг хамруулав. Судалгааны мэдээллийн статистик боловсруулалтыг SPSS программын 23 хувилбарыг ашиглан гүйцэтгэсэн. Үр дүнг хувь, дундаж үзүүлэлтээр илэрхийлсэн. Үр дүнгийн нарийвчлалын хэмжүүр (тархалтын хувь) болоод бүлгүүдийн (нас, хүйс, байршил) ялгааг тодорхойлоход 95%-ийн итгэх хязгаар (95%CI)-ын хэлбэлзлийн утгуудыг ашиглав. Чанарын мэдээллүүдийг ангилах арга зүйг баримтлан боловсрууллаа. Үүний дараа үнэлгээний удирдамжийн дагуу багц кодыг боловсруулж бүх ярилцлагуудыг кодлов. Кодлолтоор нийтлэг болон ялгаатай хүчин зүйлд үндэслэсэн тайлбарлах хандлагаар дүн шинжилгээ хийж тайланд оруулахад бэлтгэсэн.

Судалгааны ёс зүй

Судалгааны аргачлалыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн эрдэмтдийн зөвлөлөөр хэлэлцүүлж, ЭМЯ-ны анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооноос гүйцэтгэх зөвшөөрөл авч (2015/3) гүйцэтгэсэн болно.

Үр дүн

Судалгаанд нийт 3782 хүн ам хамрагдсан бөгөөд хамрагдалтын хувь 100.0 байна. Судалгаанд оролцогчдын дундаж нас 36.0 ± 14.1 , дийлэнх нь дээд (43.9%, 1662), бүрэн дунд (28.1% 1061) боловсролтой, халх (85.3%, 3225), гэрлэсэн (64.8%, 2450), 3-4 ам бүлтэй (53.5, 2024) байна. Байршлын хувьд Улаанбаатар (68.3%, 2583) хотын, буддын шашин шүтдэг хүмүүс зонхилон хамрагджээ. Оролцогчдын ам бүлийн дундаж тоо 4 ± 1.4 бөгөөд хамгийн бага нь нэг, дээд тал нь 11 ам бүлтэй байв. Судалгаанд оролцогчдын

7.0 хувь (n=265) нь ажил эрхлэх боломжтой ч ажил эрхэлдэггүй, 58.3 хувь нь ажил эрхэлдэг, 12.4 хувь нь оюутан сурагч байлаа. Цусаа бэлэглэх эерэг хандлага эмэгтэй (59.0%, 910), 18-25 насны (43.7%, 373), боловсролын түвшин өндөр хүн амын дунд статистик магадлал бүхий илүү байна. Хэдийгээр цусаа бэлэглэх талаар бодож байсан хувь УБ хотын, христын шашин шүтдэг, хамтран амьдрагчтай хүн амын дунд илүү байгаа ч статистик ач холбогдол бүхий

ялгаа ажиглагдаагүй. Хүн амын боловсролын түвшин нэмэгдэхэд цусаа бэлэглэх талаар бодож байсан оролцогчдын хувь өндөр байлаа. Тухайлбал, бүрэн бус дунд боловсролтой хүн амын 28.6 хувь нь цусаа бэлэглэх талаар бодсон бол техник мэргэжлийн боловсролтойд 39.4 хувь, дээд боловсролтойд 45.2 хувь болж нэмэгджээ. Гэхдээ боловсролгүй оролцогчдын 66.3 хувь нь цусаа бэлэглэх хандлагатай байлаа (Table 1).

Table 1. An attitude of thinking about voluntarily donating blood

Indicators	Had thought		Never thought		Total
	n	%	n	%	
Sex, 17.2=2x, p=0.000034					
Male	633	41.0	1071	47.8	1543
Female	910	59.0	1168	52.2	2239
Educational level, 94.6=2x, p=0.000001					
Uneducated	55	66.3	28	33.7	83
Only literal	2	15.4	11	84.6	13
Primary	18	33.3	36	66.7	54
Secondary	115	28.6	287	71.4	402
Secondary and high	378	35.6	683	64.4	1061
Vocational	151	39.4	232	60.6	383
Higher	751	45.2	911	54.8	1662
Master or PhD	73	58.9	51	41.1	124
Age group, 11.1=2x, p=0.012					
18-25 years	373	43.7	481	56.3	854
26-35 years	410	43.2	539	56.8	949
36-45 years	356	39.7	541	60.3	897
Above 46 years	404	37.3	678	62.7	1082
Jurisdiction, 2.59=2x, p= 0.099					
UB city	1077	41.7	1506	58.3	2583
Aimag center	466	38.9	733	61.1	1199
Religion, 5.672=2x, p=0.225					
Atheist	436	42.7	584	57.3	1020
Buddhist	822	40.1	1226	59.9	2048
Christian	65	46.8	74	53.2	139
Islam	84	39.3	130	60.7	214
Shamanist	136	37.7	225	62.3	361
Marital status, 12.33=2x p=0.015					
Single	406	42.0	561	58.0	967
Married	967	39.5	1483	60.5	2450
Living with a partner	64	54.7	53	45.3	117
Separated	37	45.7	44	54.3	81
Divorced	69	41.3	98	58.7	167
Ethnicity, 22.6=2x, p=0.0002					
Khalkh	1290	40.0	1935	60.0	3247
Kazakh	136	47.4	151	52.6	299
Buriad	42	32.6	87	67.4	155
Zakhchin	4	20.0	16	80.0	106
Other	71	58.7	50	41.3	44
Total	1543	40.8	2239	59.2	3782

Оролцогчдын цусны донорын талаарх мэдлэгийн түвшин дээшлэхэд цусаа өгөх талаар

бодож байсан хувь статистик магадлал бүхий нэмэгдэж байна ($294.51=2\sigma$, $p<0.0001$).

Table 2. Respondents knowledge, an attitude of thinking about donating blood

Knowledge level	Yes		No		Total	
	n	%	n	%	n	%
Wrong knowledge	52	3.4	188	8.4%	240	6.3%
1-3 correct answer	628	40.7	1270	56.7%	1898	50.2%
More than 4 correct answer	863	55.9	781	34.9%	1644	43.5%
Total	1543		2239		3782	

Судалгаанд оролцогчдын нас залуу байхад цусаа бэлэглэх талаар бодож байсан хувь өндөр байлаа. Тухайлбал 18-25 насны залуучуудын 43.7 хувь, 26-35 насны хүн амын 43.2 хувь нь цусаа бэлэглэх талаар бодож байсан гэжээ.

Цусаа өгөх талаар бодож байгаагүй иргэдээс яагаад гэдгийг тодруулахад 16.1 хувь нь цусаа бэлэглэж байсан, 38.2 хувь нь энэ талаар огт бодож байгаагүй гэжээ (Figure 1).




Figure 1. Main reasons why people never thought of voluntarily donating blood

Чанарын судалгаанд хамрагдсан цусны салбар төвийн мэргэжилтнүүд цусны донорын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа талаар ярьсан.

Нэг үеэ бодоход манай цусны төв шинэ барилгад орж, жил бүр, сар бүр цусны донорыг алдаршуулах, хүн амд мэдээлэл сурталчилгаа хийх ажил идэвхижсэн. Манай холбогдох мэргэжилтнүүд мэргэжлийн байгууллагаас сургалт авч чадавхижсан. Энэ жилээс сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтантай болсон. Манай олон нийтийн сүлжээ идэвхижиж хүн

амын мэдээлэл авах байдал нэмэгдэж, үүний дүнд цусны донорын тоо нэмэгдэж, жилийн хэрэгцээний цус цуглууллаа.


ЦССҮТ-ийн мэргэжилтэн

Судалгаанд хамрагдсан цусаа бэлэглэх талаар бодож байсан оролцогчдын голч нас (35 ± 14.24) энэ талаар бодож байгаагүй иргэдээс (37 ± 13.97) статистик магадлал бүхий 2 насаар залуу байсан ($p=0.000002$). Энэ нь залуучуудын дунд цусаа бэлэглэх хандлага илүүтэй байдгийг харуулж байна (Table 3).

Table 3. Average age of respondents and their thoughts on donating blood

Indicators 130.67=2x, p=0.000002	Thought about donating blood	Never thought about donating blood
Mean [95%CI]	37.5 [95%CI: 36.73-38.19]	38.53 [95%CI: 37.99-39.11]
Median [95%CI]	35 [95%CI: 34-36]	37 [95%CI: 36-38]
Standard deviation [95%CI]	14.24 [95%CI: 13.8-14.7]	13.97 [95%CI: 13.63-14.31]
Moda	30	19
Minimum	18	18
Maximum	81	82

Нийт оролцогчдын 69.2 хувь нь цусны хэрэгцээ Монгол улсад байгааг хүлээн зөвшөөрч байлаа (Figure 2).

**Figure 2. An attitude of respondents on the need for blood donors in Mongolia**

Монгол улсад цусны донорын хэрэгцээ байгаа эсэх талаарх хандлага УБ хотын иргэдэд статистикийн ач холбогдол бүхий илүү байна (122.83=2x, p=0.0001) (Table 4).

Table 4. A tendency toward blood donor needs in Mongolia

Location	Male		Female		Total %
	n	%	n	%	
UB city	812	71.3	1073	74.3	73.0
Aimag center	331	58.6	401	63.2	61.1
Soum	-	-	-	-	-
Total	1143	67.1	1474	70.9	69.2

Ярилцлагад оролцогчид бараг бүгдээрээ Монгол улсад осол гэмтэл, төрөлт их байгаа тул цусны донорын хэрэгцээ их байгаа хэмээн ярьцаасан.

Сүүлийн үед осол аваар их л гарч байна. Тийм болохоор цусны хэрэгцээ их л байж таараа. Манай аймагт (Баян-Өлгий аймаг) эмэгтэйчүүд

ойр ойрхон их төрж цус алддаг. Тийм болохоор цусны хэрэгцээ их л байна. Манайд нэгэнт донор болсон хүмүүс (казак) байдаг. Тэдгээр нь ч цусаа сайн өгдөг. Харин одоо эгнээг нь нэмэгдүүлэх л шаардлагатай байгаа юм.

Ганцаарчилсан ярилцлага, Баян-Өлгий аймаг

Судалгааны хүрээний 5 хүний нэг нь сайн дураараа цусаа бэлэглэхэд ямар нэгэн эрсдэлтэй байдаг гэсэн хандлагатай байв.

Цусаа бэлэглэхэд тухайн хүнд эрсдэлтэй гэж хариулсан оролцогчдыг боловсролын түвшингээр авч үзье (Table 5).

Table 5. Percentage of responded who answered that blood donation is risky

Education level	Blood donation entails risk for the blood donor		There is no risk in blood donation		Do not know		Total
	n	%	n	%	n	%	
Uneducated	9	10.8	14	16.9	60	72.3	83
Only literal	9	69.2	4	30.8	0	0.0	13
Primary	12	22.2	38	70.4	4	7.4	54
Secondary	77	19.2	319	79.4	6	1.5	402
Secondary and high	209	19.7	833	78.5	19	1.8	1061
Vocational	75	19.6	298	77.8	10	2.6	383
Higher	344	20.7	1297	78.0	21	1.3	1662
Master or PhD	35	28.2	88	71.0	1	0.8	124
Total	770	20.4	2728	70.8	293	7.6	3782

Оролцогчдын боловсролын түвшингээс хамаарахгүй цус бэлэглэх хүнд өөрт нь эрсдэлгүй хэмээн хариулсан оролцогчдын хувь дийлэнх нь байсан. Харин бичиг үсэгт тайлагдсан төдий хүн амын дийлэнх нь эрсдэлтэй, боловсролгүй хүмүүсийн 72.3 хувь нь мэдэхгүй гэжээ ($385.37=2x, p=0.000001$).

Цусаа бэлэглэхэд эрүүл мэндээс өөр ямар нэгэн татгалзах шалтгаан байхгүй гэж оролцогчдын 93.7 хувь (3544) нь хариулсан. Цусаа бэлэглэхэд татгалзах шалтгаан байгаа (238, 6.3%) гэсэн хүн амын дурьдсан шалтгааныг дараах зургаар үзүүлээ (Figure 3).




Figure 3. The reason why respondents failed despite their act for donating blood

Судалгаанд хамрагдсан хүн амын цусаа бэлэглэхээс татгалзаж буй гол шалтгаан нь “эрэгтэй хүний цус төлждөггүй” (139, 58.4%) гэсэн жендэрийн хэвшмэл ойлголт байгааг

тогтоосон. Эрэгтэй хүний цус төлждөггүй тул цусны донор болж болохгүй гэх ойлголт эрэгтэйчүүдийн дунд (70.7%, 95%CI: 60.4-80.9) илүү байсан (Figure 4).




Figure 4. Percentage of respondents who answered that hemopoiesis of male is poor than the female

Чанарын судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн дийлэнх нь “эрэгтэй хүн цусны донор болж цусаа өгөх нь буруу, эмэгтэй хүний цус нөхөгдөнө” гэх хандлагатай байв.

Эмэгтэй хүний биений юм сар бүр ирж л байдаг, тэд хүүхэд төрүүлдэг гээд л цус нь байгалиасаа нөхөн төлжихөөр заяагдсан. Гэтэл эрэгтэй хүн өөр. Тэд цус алдвал түүнийгээ нөхөн төлжүүлэх чадвар сул гэж ярьдаг ш пээ. Эмэгтэй, эрэгтэй 2 хүн цус

алдаад эмчлүүлбэл аягүй бол эмэгтэй нь сэхээд, эрэгтэй нь хэцүүдэх байх даа.

Эрэгтэй Н, 49 настай

Ярилцлагад хамрагдсан эмэгтэйчүүдэд “цусны донор болоход хүйсийн хамаарал чухал” хэмээх хандлага ажиглагдсан.

Цусаа өгөхөд эрэгтэй, эмэгтэй хүнд ялгаатай байх. Эрэгтэй хүүхдийг хамраас нь цус алдахад л цус багадалттай болох вий гээд л илүү их анхаардаг ш дээ.

Эмэгтэй Э, 54 настай

Цусаа бэлэглэхгүй байгаа хүн ам сүрьеэ, элэгний вирүстэй, цус багадалттай, эх барихын шалтгаантай, өндөр настай зэрэг байж болох шалтгааныг дурьдсан бол тухайн хүний гэр бүлийнхэн зөвшөөрдөггүй, айдаг, халдвар авах эрсдэлтэй, өөрөө хүсдэггүй, цаг зав муу гэсэн шалтгаанаараа цусаа бэлэглэдэггүй байна. Хэдийгээр судалгаанд оролцогчдын дийлэнх нь өөрөө цусны донор биш ч 93.9 хувь (95%CI: 93.1-94.7) цус бэлэглэх нь буян, сайн үйлс гэдэгтэй бүрэн санал нэгдэж байлаа (Table 6).

Table 6. A tendency to consider giving blood as a virtuous act

Selected indicators	Agree with blood donation is a good deed		Not agree with blood donation is not a good deed		Total
	n	%	n	%	
Sex, 0.6=2x, p=0.466					
Male	1595	93.6	109	6.4	1704
Female	1958	94.2	120	5.8	2078
Educational level, 44.26=2x, p=0.00001					
Uneducated	66	79.5	17	20.5	83
Only ileteral	11	84.6	2	15.4	13
Primary	46	85.2	8	14.8	54
Incompleted secondary	378	94.0	24	6.0	402
Complete secondary	993	93.6	68	6.4	1061
Vocational	366	95.6	17	4.4	383
Higher	1577	94.9	85	5.1	1662
Master, PhD	116	93.5	8	6.5	124
Marital status, 59.51=2x, p=0.0004					
Single	872	90.2	95	9.8	967
Married	2350	95.9	100	4.1	2450
Live with a partner	108	92.3	9	7.7	117

Separated	67	82.7	14	17.3	81
Divorced	156	93.4	11	6.6	167
Religion, 55.77=2x, p=0.00001					
Non-religious	945	92.6	75	7.4	1020
Buddhist	1961	95.8	87	4.2	2048
Christian	123	88.5	16	11.5	139
Islam	181	84.6	33	15.4	214
Shamanism	343	95.0	18	5.0	361
Total	3553	93.9	229	6.1	3782

Оролцогчдын хүйс, боловсролын түвшин, гэрлэлт, шашин шүтлэг ямар байхаас үл хамаарч цус бэлэглэх нь буянтай үйлс гэдэгтэй дийлэнх нь санал нэгдэж байлаа.

Хүмүүст амьдрал бэлэглэхэд бид сэтгэлээрээ туслахад бэлэн байна. Энэ бол хүний амь аварч байгаа сайхан үйл.

Бүлгийн ярилцлагаас

Биеийнхээ эд эрхтнээс өгнө гэдэг бол өглөгийн дээд буян. Тиймээс л цусны донор болж цусаа бэлэглэж байгаадаа хувьдаа их баяртай байдаг. Мөн өөрийн бие ч эрүүлждэг гэж сонссон.

Ганцаарчилсан ярилцлага

Тоон болон чанарын судалгаанд оролцогчид цусаа бэлэглэх нь буянтай сайн үйлс хэмээн үзсэн. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь хүмүүс цус багадана, ямар нэг өвчний улмаас, цусаа хэн өгөх талаар мэдлэггүйгээс цусаа бэлэглэдэггүй гэсэн ойлголттой байлаа (Table 7).

Table 7. The reason why respondents failed despite their act for donating blood

№	Reason of not donating a blood	n	%	95%CI	
				Min	Max
1.	Anemia	1334	35.3	32.4	38.1
2.	Chronic illness	870	23	21.7	24.4
3.	Don't know who can give your blood	512	13.5	12.4	14.6
4.	Don't know where to give my blood	190	5	4.3	5.7
5.	Risk of infection	402	10.6	9.2	12.1
6.	Busy	162	4.3	3.6	4.9
7.	Afraid run down your health	150	4	3.4	4.6
8.	Afraid needles	313	8.3	7	9.6
9.	Many were born	43	1.1	0.8	1.5
10.	Men can't well hemopoiesis	82	2.2	1.7	2.6
11.	All the above causes	192	5.1	4.4	5.7
12.	Total	3782	100	100	100

Судалгаанд оролцогчдын 82.2 хувь нь цусаа бэлэглэж байгаа хүмүүс бусдад тусалж, хүний амь нас аварч байгаа нь тэдэнд таалагдаж байгаа тул цусаа бэлэглэсээр байдаг гэх хандлага давамгайлж байна.

Хэлцэмж

Бидний судалгаагаар хүн амын 60 орчим хувь нь цусаа сайн дураараа бэлэглэх талаар өмнө нь бодож байгаагүй гэжээ. Гэхдээ сүүлийн жилүүдэд нийгэмд сайн үйл хийх хүсэл тэмүүлэл, сайн үйл хийж буй хүнээр бахархах хандлага давамгайлж байгаа нь цусны донорын эгнээг нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлж байж болохыг чанарын судалгааны дүн харуулсан. Дэлхийн олон оронд хийгдсэн судалгаагаар цусны донорын эгнээг нэгтгэхэд сөргөөр нөлөөлдөг нь хүн амын айдас болохыг судлаачид дурьдсан байна. Саудын Араб болон Энэтхэгт хийсэн судалгаанд (Junu Hada, 2005) зүү тариураас айх, халдвар авах, цус багадаа эрсдэл нэмэгдэнэ гэсэн нь бидний судалгааны дүнтэй ойролцоо байлаа [7]. Заллер нарын (2005) БНХАУ-д хийсэн судалгаагаар нийгмийн зүгээс үзүүлдэг дарамт, цусны шинжилгээ өгч өөрийн эрүүл мэндийн байдлыг мэдэх хүсэл нь цусны донорын эгнээг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг болох нь бидний судалгааны үр дүнгээс ялгаатай байлаа [8]. Хөгжиж буй улс орнуудын хүн амын цусны донорын талаарх мэдлэг, хандлага тогтоосон 18 судалгааны тоймд цусны донорын талаарх буруу ойлголт, айдас, цусыг нь зарах вий гэх болгоомжлол нь цусаа бэлэглэх хандлагад сөргөөр нөлөөлдөг хэмээн дүгнэжээ [9]. Саудын Арабын 20-45 насны хүн амыг хамруулсан судалгаагаар хүн амын цусны донорын талаарх мэдлэг, хандлага сайн, цусны донорын тархалт өндөр байгааг тогтоосон байна [10].

Олон улс оронд хийсэн судалгааны дүнгээр хүн амын цусны донорын талаарх мэдээллийн дутагдалтай байдал болон аливаа эрсдлээс айх айдас цусны эгнээг нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлдөг болохыг тогтоосон байна [11-15].

Энэтхэгийн хүн амын цусаа бэлэглэхгүй байгаад саад болж буй хамгийн чухал шалтгаан нь хувь хүний эрүүл мэндийн байдал болохыг тогтоожээ [16]. Мөн хүн амын дунд тархсан домог ярианд анхаарал хандуулж шинжлэх ухаанч тайлбарыг өгч, ЕБС-иудад цусны донорын сургалтыг оруулж байхыг чухалчилсан байлаа [17].

Бидний судалгаанд хамрагдсан цусаа бэлэглэх талаар бодож байсан оролцогчдын голч нас (35 ± 14.24) энэ талаар огт бодож байгаагүй иргэдээс (37 ± 13.97) 2 насаар залуу байгаа нь залуучуудын дунд цусаа бэлэглэх хандлага илүү байдгийг харуулсан. Монголчуудын 90 гаруй хувь нь цус бэлэглэх нь буян, сайн үйлс гэдэгтэй бүрэн санал нийлдэг байна. Бидний судалгааны

дүнгээс харахад цусны донор болох хүн амын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь мэдлэгийн түвшин цусаа бэлэглэх хандлагад шууд нөлөө үзүүлсэн байж болохыг харуулсан. Монгол Улсад өдөрт 100 орчим донор цусаа өгч байж эмнэлгүүдийн тайван үеийн хэрэгцээг хангана гэж тооцоолдог. ДЭМБ-аас тухайн улсын хүн амын 3% нь байнгын донор байхад улс өөрийн орны цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээг хангаж чадна хэмээн тооцоолсон байдаг [1]. Хэдийгээр цусны донорын тоо манай улсад нэмэгдэж байгаа ч өдөрт 100 орчим донор цусаа өгч чаддаггүй байна [18].

Дүгнэлт:

Цус хандивлах хандлага 20-29 насны залуучууд, эмэгтэйчүүд, Улаанбаатар хотын иргэд, боловсролгүй болон магистраас дээш боловсролтой хүн амын дунд илүү байна. Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь цус хандаивлах нь буянтай сайн үйл гэдэгтэй санал нэг байсан. Сайн дураар цус хандивлахад тухайн хүний боловсрол, хүйс, сайн үйлс хийх хүсэл, хамт олны нөлөө болон эрүүл мэндийн шалтгаан тус тус нөлөөлж байна.

Талархал

Энэхүү судалгааг АХБ-ны эрүүл мэндийн салбарын хөгжилт хөтөлбөр-5 төслийн санхүү, техникийн туслалцаатай гүйцэтгэсэн бөгөөд ЭМЯ-ны холбогдох мэргэжилтэн болон төслийн хамт олонд талархал илэрхийлье.

Ном зүй

1. WHO. Global status report on blood safety and availability 2016. WHO, Geneva, Switzerland, 2017.
2. World blood donor day 2019. Blood connects us all. Available from: <http://https://www.who.int/campaigns/world-blood-donor-day/2019>.
3. WHO. Giving blood in a time of crisis. Global health days, World Blood Donor Day, 2018.
4. Монгол улсын цус цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах үндэсний хөтөлбөр. МУЗГ-ын 1997 оны 1974 дүгээр тогтоол.
5. Монгол улсын Донорын тухай хууль. 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр.
6. Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 01 дугаар журам батлах тухай тушаалын 4 дүгээр хавсралт. Донорт сургалт, сурталчилгаа хийх, элсүүлэх, бүртгэх, хадгалах журам.

7. Zaller N., Nelson KE., Ness P., Wen G., Bai X., Shan H. Knowledge, attitude and practice survey regarding blood donation in a Northwestern Chinese city. *Transfus Med.* 2005; 15(4):277-86.
8. Hada, J.A. "A research report on knowledge, attitude and practice on blood donation among 18-25 years bachelor level people." Hope International College, 2008:1-30.
9. Lownik E., Riley E., Konstenius T., Riley W., McCullough J. Knowledge, attitudes and practices surveys of blood donation in developing countries. *Vox Sang.* 2012; 103(1):64-74.
10. Baig M, Habib H, Haji AH, Alsharief FT, Noor AM, Makki RG. Knowledge, misconceptions and motivations towards blood donation among university students in Saudi Arabia. *Pak J Med Sci* 2013;29(6):1295-1299.
11. Kowsalya V, Vijayakumar R, Chidambaram R, Srikumar R, Reddy EP, Latha S, et al. A study on knowledge, attitude and practice regarding voluntary blood donation among medical students in Puducherry, India. *PJBS.* 2013; 16:439-42.
12. Hayder Mohammed, Tarig Osman. Voluntary blood donation among medical students in a resource-limited country. *JPHDC.* 2016; 2(3):257-267.
13. Bharatwaj R, Vijaya K, Rajaram P. A descriptive study of knowledge, attitude and practice with regard to voluntary blood donation among medical undergraduate students in Pondicherry. *J Clin Diagn Res.* 2012; 6:602-604.
14. Dansekaran R, Mani G, Annadurai K. A Cross-sectional study on Awareness and Practices about Blood donation among Medical students. *IJMRD.* 2014; 1:131-4.
15. Renu Chauhan, Rajesh Kumar, Supriya Thakur. A study to assess the knowledge, attitude, and practices about blood donation among medical students of a medical college in North India. *J Family Med Prim Care.* 2018; 7(4): 693-697.
16. Chopra D, Jauhari N. Knowledge Attitude & Practices towards Voluntary Blood Donation among Medical Students in Barabanki District, India. *Indian J Community Health.* 2015; 27:386-390.
17. Mishra SK., Sachdev S, Marwaha N., Avasthi A. Study knowledge and attitude among college-going students toward voluntary blood donation from north India. *J Blood Med.* 2016; 16(7):19-26.
18. ЭМХТ. МТА. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд, 2018.

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Анагаах ухааны доктор Б.Ичинхорлоо*